



Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 24

№363

Улаанбаатар
хст

Улсын үйлдвэрийн газар
байгуулах тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн Ү бүлгийн 40 дүгээр зүйлийг үндэслэж Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны Зураг төсвийн товчоог татан буулгаж "Улсын үйлдвэрийн газар" болгон зохион байгуулж "Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны Зураг төслийн товчоо" нэрээр байгуулсугай.

2. Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны Зураг төслийн товчооны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1990 оны 108 дугаар тогтоол, мөн оны 228 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тосцугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

[Handwritten signature]

Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Handwritten signature] Б.БОЛСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны ТӨВТ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ЗУРАГ ТӨС-
ЛИЙН ТОВЧООНЫ ДҮРЭМ**

Хотын зураг төслийн товчоо нь нийслэл болон түүний дагуул хотын нутаг дэвсгэр дэх орон сууцны хороолол, сургуулиудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зохиох, түүний дагуу баригдах орон сууц, соёл ахуй үйлчилгээний барилгын зураг төсөв боловсруулах, тэдгээрийн холболт өргөтгөл, шинэчлэлт, засвар, мөн хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлт, гэрлэн чимэглэл, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсвийг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаан түүний харьяа газрууд болон үйлдвэр, аж ахуй, албан байгууллагуудын захиалгаар чанартай боловсруулах үүргийг хүлээнэ.

1. Зураг төслийн товчооны зорилго:

а/ Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны болон хотын захын хорооллуудын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалт, архитектур төлөвлөлтийн өндөр түвшинд, байгаль цаг уур, үндэсний онцлогийг тусгасан эдийн үр ашигтай хувилбараар боловсруулах;

б/ Барилга байгууламжийг ур хийц архитектур төлөвлөлт, өнгө үзэмжийн хувьд орчны барилгажилттай зөв хосолж, барилгын үйлдвэрлэлтэй нягт уялдуулан ашигтай хувилбараар төлөвлөх;

в/ Хот, суурингийн барилгажилт, тохижилтын өнгө үзэмжийг эрс сайжруулахуйц, хүмүүсийг аятай тухтай амьдарч хөдөлмөрлөх бүх нөхцлийг бүрдүүлсэн тохижилтын зургийг боловсруулж түүнд хэрэглэгдэх архитектурын жижиг хэлсэрүүдийг тухайн орчинтой нь уялдуулан өвөрмөц сондрхолтой байхаар сонгож төсвийг зохиох;

г/ Инженерийн шугам сүлжээ, тэдгээрийн эх үүсвэрийн зураг төслийг зохиохдоо хэтийн төлөвийг нарийн тооцож, цаашид удаан хугацаагаар ашиглах боломжтой байхаар төлөвлөж гүйцэтгэх;

д/ Гэрлэн чимэглэл-рекламын эскиз-зургийг боловсруулахдаа ур хийц, өнгө үзэмж, урга агуулгын зөв хослолттой, шинжлэх ухаан техникийн дэвшилтэт техник технологийг бүрэн тусгасан хотын өнгө үзэмжийг сайжруулах чиглэлийг баримтлах;

2. Зураг төслийн товчоо нь үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, холбогдох дээд байгууллагын тогтоол шийдвэр, бусад эрхийн актуудыг мөрдөж ажиллана.

3. Зураг төслийн товчоо нь үйл ажиллагаанд хувьд Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанд шууд захирагдана.

4. Хот байгуулалт төлөвлөлтийн газар нь хот байгуулалтын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс тус товчооны үйл ажиллагаанд техникийн нэгдсэн удирдлагаар хангах үүргийг хүлээнэ.

5. Улаанбаатар хотын Зураг төслийн товчоо нь аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиглана.

6. Зураг төслийн товчооны охион байгуулалтын бүрэлдэхүүнд ерөнхий төлөвлөгөөний хэсэг, хот тохижилт, гэрлэн чимэглэлийн хэсэг, барилга-засварын хэсэг гэсэн нэгжүүд багтана.

7. Зураг төслийн товчоо нь үйл ажиллагааныхаа зорилтыг биедүүлэх явцад өөртөө орон тооны бус техникийн зөвлөл, захиргааны хурлын гишүүдийг томилон ажилдуулна.

8. Хотын зураг төслийн товчоо нь хуулийн этгээд бөгөөд батлагдсан тэмдэг, алоам бичгийн нүүр хэрэглэнэ.

9. Зураг төслийн товчооны үүрэг:

а/ Нийслэл, түүний дагуул хот суурингийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө шинээр баригдах барилга, байгууламж, түүний аргэтгэл, шинэчлэлт, тохижилт, гэрлэн чимэглэл, инженерийн шугам сүлжээ, их засварын зураг төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм дүрэм /СНИП/ бусад тогтоол, заавар зэрэг эрхийн актуудыг мөрдөж ажиллана.

б/ Тус товчоонд зураг төсөл нь боловсруулагдсан объектын гүйцэтгэлийн явцад аж ахуйн гэрээний дагуу зохиогчийн хяналт тавина.

в/ Бөрсдийн буруугаас зураг төсөвт алдаа илэрсэн тохиолдолд тогтоосон хугацаанд нь үнэгүйгээр засч өгөх.

10. Зураг төслийн товчооны эдлэх эрх:

Зураг төслийг боловсруулах технологи ажиллагаанд харшилсан материал бүрдүүлсэн захиалагчтай аж ахуйн гэрээ байгуулахаас татгалзах: Үүнд:

- газар олголт, зургийн даалгавар, техникийн нөхцөл, гүйцэтгэгчийн зөвшөөрөл, технологийн зураг гэх мэт материал зорчилтөй тохиолдолд;

- Зохиогчийн хяналтын явцад зураг төсвийг зөвшөөрөлгүй өөрчлөн гүйцэтгэсэн нөхцөлд уул ажлыг зогсоох саналаа Хот байгуулалт төлөвлөлтийн газрын хяналтын албанд тавих;

- Зураг төсөв зохиох явцад шаардлагатай судалгаа болон нэмэлт материалыг захиалагч, ашиглагч байгууллагаас гаргуулах.

II. Хотын Зураг төслийн товчоо нь өөрийн үйл ажиллагааны тайлангаа жил бүр гаргаж хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргаанд хэлэлцүүлнэ.